

GOV.MN

Хэрэглэгчийн гарын авлага

Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас — www.gov.mn — сайтыг ашиглах дэлгэрэнгүй заавар.

[Алхам алхмаар заавар](#)[Дэлгэцийн зурагтай](#)[2026 оны хувилбар](#)

Агуулга

- 1 GOV.MN гэж юу вэ?
- 2 Нүүр хуудасны тойм ба хайлт
- 3 ДАН системээр нэвтрэх — алхам алхмаар
- 4 Нээлттэй өгөгдөл, мэдээлэл
- 5 Иргэдийн оролцооны систем. Иргэн төрийн байгууллагын шийдвэр гаргалтад оролцох цахим системүүд
- 6 Мэдээ унших
- 7 Төрийн байгууллага хайх
- 8 Ажлын байр хайх
- 9 Ажлын байрны дэлгэрэнгүй, анкет илгээх
- 10 Түгээмэл асуулт, хариулт
- 11 Нэр томъёоны тайлбар
- 12 Холбоо барих

1. GOV.MN гэж юу вэ?

GOV.MN бол Монгол Улсын төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэл, үйлчилгээг нэг дороос авах боломж олгодог **төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас** юм. Та энэ сайтаар дамжуулан төрийн үйлчилгээ авах, мэдээ мэдээлэл унших, төрийн байгууллагуудын танилцуулга үзэх, нээлттэй ажлын байранд хүсэлт гаргах, хууль тогтоомжийн төсөлд саналаа өгөх боломжтой.

3 807

Төрийн байгууллагын танилцуулга

1 102

Нээлттэй ажлын байрны зар

6.8 сая+

Нийт хандалтын тоо

24/7

Хэзээ ч, хаанаас ч хандах боломж


Сайт руу орохын тулд интернэт хөтөч (Chrome, Edge, Safari гэх мэт) нээгээд хаягийн мөрөнд **www.gov.mn** гэж бичээд Enter товч дарна.

ЗӨВЛӨМЖ

Сайтыг компьютер, таблет, гар утас аль ч төхөөрөмжөөс ашиглаж болно. Ахмад настнуудад үсэг томруулах бол хөтчийн Ctrl болон «+» товчийг зэрэг дарж дэлгэцийг томруулахыг зөвлөж байна.

2. Нүүр хуудасны тойм ба хайлт

Нүүр хуудас нь сайтын гол хэсгүүд рүү хүрэх хамгийн хурдан зам юм. Доорх зурагт нүүр хуудасны үндсэн хэсгүүдийг дугаарлан тэмдэглэв.



Зураг 1. GOV.MN нүүр хуудас (www.gov.mn/home)

- 1 Мэдээллийн зурвас** — тухайн өдрийн ам.долларын ханш, цаг агаар, огноо харагдана.
- 2 GOV.MN лого** — аль ч хуудаснаас дарахад нүүр хуудас руу буцаана.
- 3 Тохиргооны товчнууд** — хууль эрх зүйн мэдээлэл, хараа сулавтар хүмүүст зориулсан хялбар горим, шөнийн (харанхуй) горим.
- 4 «Нэвтрэх» товч** — өөрийн бүртгэлээр нэвтэрч, нэмэлт үйлчилгээ авахад ашиглана (3-р бүлгийг үзнэ үү).
- 5 Хайлтын талбар** — үйлчилгээ, хууль, яам, засгийн газрын нэгжүүдээр хайна.
- 6 «Төрийн байгууллагын цахим хуудас»** — бүх төрийн байгууллагын нэгдсэн жагсаалт руу шилжинэ (7-р бүлгийг үзнэ үү).
- 7 «Төрийн үйлчилгээ — Иргэн»** — иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний нэгдсэн лавлах руу шилжинэ (e-mongolia).
- 8 «Төрийн үйлчилгээ — Аж ахуйн нэгж»** — байгууллага, бизнес эрхлэгчдэд зориулсан үйлчилгээний лавлах руу шилжинэ (e-mongolia).
- 9 «Өргөдөл гомдол илгээх»** — 11-11 төвийн нэгдсэн системээр өргөдөл, гомдол илгээх хуудас руу шилжинэ.

Хайлт хэрхэн хийх вэ?

- 1 Нүүр хуудасны голд байрлах хайлтын талбар дээр дарна.
- 2 Хайх зүйлээ монголоор бичнэ. Жишээ нь: «жолооны үнэмлэх», «эрүүл мэндийн даатгал», «газрын харилцаа».
- 3 Гарын Enter товч эсвэл талбарын баруун талын томруулдаг шилний зураг дээр дарна.
- 4 Гарч ирсэн үр дүнгээс өөрт хэрэгтэйг сонгож дарна.

АНХААРНА УУ


Хайлтад үг буруу бичигдвэл үр дүн олдохгүй байж болно. Аль болох товч, зөв бичгийн дүрмийн дагуу бичихийг хичээгээрэй.

3. ДАН системээр нэвтрэх — алхам алхмаар

ДАН (Үндэсний танилт, нэвтрэлтийн систем) нь төрийн цахим үйлчилгээнд нэг бүртгэлээр нэвтрэх нэгдсэн систем юм. GOV.MN дээр нэвтэрснээр өргөдөл гомдол илгээх, хэлэлцүүлэгт санал өгөх зэрэг нэмэлт боломжууд нээгдэнэ.

Алхам 1. «Нэвтрэх» товч дарж, нэвтрэх төрлөө сонгох

Нүүр хуудасны баруун дээд буланд байрлах хөх өнгийн **«Нэвтрэх»** товчийг дарахад доорх цонх гарч ирнэ.




Зураг 2. «Системд нэвтрэх» цонх

- 1 **«Иргэнээр нэвтрэх»** — энгийн иргэн та энэ сонголтыг ашиглана.
- 2 **«Админаар нэвтрэх»** — зөвхөн төрийн байгууллагын ажилтнуудад зориулагдсан.
- 3 **«Дан системээр нэвтрэх»** товчийг дарж дараагийн алхам руу шилжинэ.

Алхам 2. ДАН системд бүртгэлээрээ нэвтрэх

Таныг sso.gov.mn хаягтай ДАН системийн хуудас руу шилжүүлнэ. **Энд** хэд хэдэн аргаар нэвтрэх болно.



Зураг 3. ДАН — Үндэсний танилт, нэвтрэлтийн систем (sso.gov.mn)

- 1 Нэвтрэх аргаа сонгох** — «Нэг удаагийн код», «Банкны эрх», «Тоон гарын үсэг» гэсэн сонголтууд бий.
- 2 «Регистрийн дугаар»** эсвэл «Иргэний бүртгэлийн дугаар»-аар нэвтрэхээ сонгоно.
- 3** Регистрийн үсгээ сонгож, дугаараа бичнэ. Жишээ: **РД 95147350**.
- 4 Нууц үгээ** бичнэ. Мартсан бол «Нууц үгээ мартсан уу?» холбоос дээр дарж сэргээнэ.
- 5** Хөх өнгийн **«Нэвтрэх»** товчийг дарна. Бүртгэлгүй бол «Бүртгүүлэх» товчоор шинээр бүртгүүлнэ.
- 6 QR кодоор нэвтрэх** — ДАН гар утасны аппликейшнтэй бол QR уншигчаар кодыг уншуулж нууц үггүйгээр нэвтрэх болно.

АНХААРНА УУ


Нууц үгээ хэнд ч бүү хэлээрэй. Төрийн байгууллага таны нууц үгийг утсаар болон мессежээр хэзээ ч асуухгүй. Нийтийн компьютер ашигласан бол ажлаа дуусгаад заавал гарахаа мартуузай.

ЗӨВЛӨМЖ

ДАН бүртгэлгүй бол App Store эсвэл Google Play-ээс «DAN» аппликейшн татаж, зааврын дагуу бүртгүүлээрэй. Нэг бүртгэлээр E-Mongolia зэрэг бусад төрийн системд ч нэвтэрнэ.

4. НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЭЛ

Нүүр хуудаснаас доош гүйлгэхэд төрийн нээлттэй мэдээллийн системүүдийн холбоосууд харагдана. Эдгээр нь тус тусдаа бие даасан сайтууд бөгөөд картан дээр дарахад шууд шилжинэ.



Зураг 4. Нээлттэй өгөгдөл, нийтийн мэдээллийн системүүд

- 1 **«Нээлттэй өгөгдөл, мэдээлэл»** хэсэг — shilen.gov.mn (Шил ажиллагаа), shilendans.gov.mn (Шилэн данс), opendata.gov.mn (Нээлттэй өгөгдлийн портал), tender.gov.mn (Төрийн худалдан авалт).
- 2 Карт бүр дээр сайтын хаяг, товч тайлбар бий. Дарахад тухайн сайт шинэ цонхонд нээгдэнэ.
- 3 **«Нийтийн мэдээллийн систем»** хэсэг — license.mn (зөвшөөрөл), egazar.gov.mn (газар), auth.itc.gov.mn (татвар), ehalamj.mn (халамж) зэрэг системүүд.
- 4 **Сум товчнууд** — баруун, зүүн сумаар нэмэлт картуудыг гүйлгэж үзнэ.


5. Иргэдийн оролцоо ба хэлэлцүүлэг

Энэ хэсэгт төрийн шийдвэр гаргах үйл явцад дуу хоолойгоо хүргэх цахим системүүд бий :

Төрийн гүйцэтгэх дээд байгууллага (e-zasag.mn)

Хууль тогтоох дээд байгууллага (d.parliament.mn)

Хуулийн төсөлд санал өгөх (legal.info.mn)



Зураг 5. Иргэдийн оролцоо ба хэлэлцүүлгийн хэсэг

- 1 «Иргэдийн оролцоо» — иргэдийн оролцоог хангах цахим талбар.
- 2 Онцлох арга хэмжээ — жишээ нь UNCCD COP17 Улаанбаатар 2026 бага хурлын мэдээлэл. «Дэлгэрэнгүй үзэх» товчоор нээнэ.
- 3 «Хэлэлцүүлэг» — санал авч буй хуулийн төслүүдийн жагсаалт. «Бүгдийг үзэх» товчоор бүх хэлэлцүүлгийг харна.
- 4 Ногоон тэмдэглэгээ «Санал авч байгаа» — одоогоор санал өгч болохыг илтгэнэ.
- 5 Карт бүрийн доод хэсэгт хариуцсан яам, дэмжсэн/эсэргүүцсэн саналын тоо харагдана.

Хэлэлцүүлэгт санал өгөх

- 1 ДАН системээр нэвтэрсэн байх шаардлагатай (3-р бүлгийг үзнэ үү).


- 2 «Санал авч байгаа» тэмдэглэгээтэй хэлэлцүүлгийн карт дээр дарж дэлгэрэнгүйг нээнэ.

3

Хуулийн төслийг уншиж танилцаад, дэмжих/эсэргүүцэх сонголтоо хийх буюу бичгэн саналаа үлдээнэ.

6. Мэдээ унших

«Онцлох мэдээ» хэсэгт төрийн байгууллагуудын **хамгийн** чухал мэдээ, үйл явдлууд **байрлана**. Хуудасны доод хэсэгт (хөл хэсэг) холбоо барих мэдээлэл, хандалтын статистик харагдана.




Зураг 6. Онцлох мэдээ ба хуудасны хөл хэсэг

- 1 «Онцлох мэдээ» — өнөөдрийн **хамгийн** чухал үйл явдлууд.
- 2 Гол мэдээ — том зурагтай, **ОНЦОЛСОН** мэдээ. Дарахад бүрэн эхээр нээгдэнэ.
- 3 Мэдээний жагсаалт — мэдээ бүр дээр нийтэлсэн байгууллага, огноо, таалагдсан тоо харагдана.
- 4 «Бүгдийг үзэх» — бүх мэдээний нэгдсэн жагсаалт руу шилжинэ.
- 5 Хөл хэсэг — 11-11 төв, имэйл, албан ёсны сошиал хуудсууд, хандалтын тоо.

7. Төрийн байгууллага хайх

Зүүн талын цэснээс «Төрийн байгууллагууд» хэсгийг сонгоход 3 807 байгууллагын нэгдсэн жагсаалт нээгдэнэ. Байгууллага бүрийн танилцуулга, үйлчилгээ, холбоо барих мэдээллийг эндээс авна.




Зураг 7. Төрийн байгууллагуудын жагсаалт

- 1 Зүүн талын цэс** — Нүүр хуудас, Мэдээ, Төрийн байгууллагууд, Ажлын байр, Хэлэлцүүлэг, Хөтөч гэсэн үндсэн хэсгүүд.
- 2 Хайлтын талбар** — байгууллагын нэрийг бичиж хайна.
- 3 Цагаан толгойн шүүлтүүр** — А, Б, В... үсгээр дарж тухайн үсгээр эхэлсэн байгууллагуудыг харна.
- 4 «Шүүж харах»** — салбар, төрлөөр нь нарийвчлан шүүнэ.
- 5 Харагдах байдал** — сүлжээ эсвэл жагсаалт хэлбэрээр солино.
- 6 Байгууллагын картууд** — нэр дээр нь дарахад дэлгэрэнгүй танилцуулга нээгдэнэ.

8. Ажлын байр хайх

Зүүн цэснээс «Ажлын байр» хэсгийг сонгоход төрийн байгууллагуудын нээлттэй ажлын байрны нэгдсэн зар харагдана.



Зураг 8. Ажлын байрны нэгдсэн зар

- 1 «Ажлын байр» цэс — идэвхтэй үед цэнхэр өнгөөр тодорно.
- 2 Хайлт — байгууллагын нэрээр хайна.
- 3 «Шүүж харах» — байршил, салбар, ажлын төрлөөр шүүнэ.
- 4 Нийт зарын тоо — жишээ нь «Нийт: 1102 ажлын байр».
- 5 Зарын карт — албан тушаал, байгууллага, байршил, хүлээн авах эцсийн огноо харагдана.
- 6 Төлөвийн тэмдэглэгээ — «Нээлттэй», «Бүтэн цагийн», «Ээлжийн» ГЭХ МЭТ.

9. Ажлын байрны дэлгэрэнгүй, анкет илгээх

Сонирхсон зар дээрээ дарахад дэлгэрэнгүй мэдээлэл нээгдэнэ. Эндээс цалин, шаардлага, холбоо барих мэдээллийг харж, анкетаа илгээнэ.

The screenshot shows the GOV.MN portal interface. The sidebar on the left contains links: Нүүр хуудас, Мэдээ, Төрийн байгууллагууд, Ажлын байр, Хэлэлцүүлэг, and Хөтөч. The main content area displays job details for 'Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар'. It includes a salary section showing 'Цалин: 1,555,000 ₮ - 1,555,000 ₮', a table of job details (Байршил, Салбар, Төрөл, Түвшин, Орон тоо), and contact information (Холбоо барих, Анкет хүлээн авах, Хүлээн авч эхлэх огноо, Хүлээн авч дуусах огноо). A 'Анкет татах' button is at the bottom.

Зураг 9. Ажлын байрны дэлгэрэнгүй хуудас

- 1 «Буцах» — зарын жагсаалт руу буцна.
- 2 Албан тушаал, байгууллага — зарын гарчиг хэсэг.
- 3 Цалингийн мэдээлэл — санал болгож буй цалингийн хэмжээ.
- 4 Дэлгэрэнгүй талбарууд — байршил, салбар, төрөл, түвшин, орон тоо.
- 5 Холбоо барих — утас, анкет хүлээн авах имэйл хаяг, эхлэх/дуусах огноо.
- 6 «Анкет татах» — төрийн албан хаагчийн анкетын загварыг татаж авна.

Анкет илгээх дараалал

- 1 «Анкет татах» товчийг дарж анкетын файлыг компьютертоо хадгална.
- 2 Анкетыг үнэн зөв, бүрэн бөглөнө.
- 3 Бөглөсөн анкетаа заранд заасан имэйл хаяг руу (жишээ: dornodcd@gmail.com) хавсаргаж илгээнэ.

4 Хариу хүлээнэ. Шаардлагатай бол заранд заасан утсаар лавлана.

АНХААРНА УУ

Анкет хүлээн авах **дуусах огноог** сайтар шалгаарай. Хугацаа хэтэрсэн анкетыг хүлээн авахгүй.

10. Түгээмэл асуулт, хариулт

Сайтад нэвтрэхгүйгээр юу үзэж болох вэ?

Мэдээ, төрийн байгууллагуудын танилцуулга, ажлын байрны зар, хэлэлцүүлгийн жагсаалт зэрэг ихэнх мэдээллийг нэвтрэхгүйгээр үзэж болно. Санал өгөх, өргөдөл илгээх зэрэгт нэвтрэх шаардлагатай.

ДАН нууц үгээ мартсан бол яах вэ?

ДАН нэвтрэх хуудасны «Нууц үгээ мартсан уу?» холбоос дээр дарж, бүртгэлтэй утасны дугаараар баталгаажуулан шинэ нууц үг үүсгэнэ.

Дэлгэцийн үсэг жижиг харагдаж байна. Томруулж болох уу?

Болно. Гарын Ctrl товч болон «+» товчийг зэрэг дарж томруулна («-» товчоор багасгана). Мөн сайтын баруун дээд буланд хараа сулавтар хүмүүст зориулсан хялбар горимын товч бий.

Өргөдөл, гомдлоо хэрхэн илгээх вэ?

Нүүр хуудасны «Өргөдөл гомдол илгээх» товчоор дамжин 11-11 төвийн нэгдсэн системд хандана. ДАН-аар нэвтэрсэн байх шаардлагатай.

Гар утаснаас ашиглаж болох уу?

Болно. Гар утасны хөтчөөр www.gov.mn руу орход дэлгэцэд тохирсон хувилбар нээгдэнэ. Төрийн үйлчилгээг гар утаснаас авахад E-Mongolia аппликейшн бас тохиромжтой.

Хуучин хувилбарын сайтыг ашиглаж болох уу?

Сайтын дээд зурваст байрлах «Өмнөх хувилбар ашиглах» холбоосоор хуучин хувилбар руу шилжиж болно. Мөн «Монгол бичгийн хувилбар» сонголтоор уйгаржин монгол бичгээр үзэх боломжтой.

11. Нэр томьёоны тайлбар

НЭР ТОМЬЁО	ТАЙЛБАР
ДАН	Үндэсний танилт, нэвтрэлтийн систем. Төрийн цахим үйлчилгээнд нэг бүртгэлээр нэвтрэх нэгдсэн систем.
Регистрийн дугаар	Иргэн бүрд олгогдсон 2 үсэг, 8 оронтой тооноос бүрдэх бүртгэлийн дугаар.
QR код	Гар утасны камераар уншуулж мэдээлэл дамжуулдаг дөрвөлжин код.
Хөтөч (браузер)	Интернэт сайт үзэх программ: Chrome, Edge, Safari, Firefox гэх мэт.
Хэлэлцүүлэг	Хууль тогтоомжийн төсөлд иргэдээс санал авах цахим талбар.
Шилэн данс	Төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн мэдээллийг ил тод харуулах систем.
Нээлттэй өгөгдөл	Хэн ч үнэ төлбөргүй ашиглаж болох төрийн мэдээллийн сан.
Анкет	Төрийн албан хаагчийн ажилд орох хүсэлтийн маягт.
E-Mongolia	Төрийн үйлчилгээг цахимаар авах нэгдсэн систем (аппликейшн болон вэб).
Тоон гарын үсэг	Цахим баримт бичигт зурдаг, хуулийн хүчинтэй цахим гарын үсэг.

12. Холбоо барих

Сайт ашиглахтай холбоотой асуулт, санал хүсэлтээ дараах сувгуудаар илгээнэ үү.

ЛАВЛАХ УТАС

11-11

Засгийн газрын иргэд, олон нийттэй
харилцах төв

ИМЭЙЛ

1111@gov.mn

Санал хүсэлт, асуулт илгээх хаяг

ЦАХИМ ХУУДАС

11-11.mn

Өргөдөл, гомдлын нэгдсэн систем

АВЛИГЫН МЭДЭЭЛЭЛ

11-10

АТГ-т хандах утас

GOV.MN

Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас

Хэрэглэгчийн гарын авлага · 2026 он

www.gov.mn